

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Монголбанкинд сервер, сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **Б-2017/5**

Монголбанк эрх бүхий тендерт оролцогчоос **сервер, сүлжээний тоног төхөөрөмж** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрд лээр нь 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд (дансны нэр: тендерийн хороо) тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Борлуулалтын хэмжээ: **Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй байна**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жил: **2014, 2015, 2016 он**

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгох үнийн дүнгийн **2 хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгааг** ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 15 цаг 00 минутаас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 15 цаг 40 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МОНГОЛБАНК

Бага тойруу-3, 15160, Улаанбаатар хот,
Монголбанкны “Өргөтгөл” байрны 2 дугаар давхар, 37 тоот өрөө,
Утас: (976-11) 311039, факс: (976-11) 311471